

ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖЭЭЧ ЭМЧ

“АХЛАХ” зэрэг горилогч шүүх эмнэлгийн шинжээч эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо /мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд жил бүр хамрагдсан байх, (сертификатаар баталгаажуулна).
2. Эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож 4-өөс доошгүй бүтээлийг тус бүр мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна. Үүнд ховор тохиолдол -2 (Өөрөө болон бусад эмч нартай хамтран оношилсон байх), судалгааны илтгэл-2 (илтгэлүүдэд 1-р судлаач байх)
3. Шинжээч эмчийн мэргэжлийн чадвар эзэмшсэн байна.
4. Тухайн мэргэжлээрээ тасралтгүй 8 жил ажилласан байх, сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайланг бичгээр илгээх.

“ТЭРГҮҮЛЭХ” зэрэг горилогч шүүх эмнэлгийн шинжээч эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна .

Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд жил бүр хамрагдсан байна.
2. Эрдэм шинжилгээний судалгааны ажил хийж, сүүлийн 5 жилд 6-аас цөөнгүй бүтээлийг хэвлэн нийтлүүлсэн байна. (Өөрөө болон бусад эмч нартай хамтран оношилсон ховор тохиолдол-2 оос дээш, эрдэм шинжилгээний илтгэл-3, нэгдүгээр зохиогчоор судалгааны өгүүлэл-3) тус бүрийг мэргэжлийн сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн байна.
3. Шүүхийн шинжээч залуу эмч нар, ахлах зэрэгтэй шинжээч эмч нарт зөвөлгөө өгөх, мэргэжил, арга зүйгээр хангах чадвар эзэмшсэн байх
4. Шүүх эмнэлгийн шинжилгээгээр гэмтэл, эмгэг, өвчнийг олон улсын ангиллаар бие дааж үнэлэх, дүгнэх чадвартай байх.
5. Шүүх анагаах ухааны шинэ технологи, инновацид суралцсан байх (шүүх генетик, шүүх хор судлал, шүүх эд судлал, ИГХ-ийн будаг/биомаркерийн үр дүнг үнэлэх чадвар эзэмшсэн бол давуу тал болно)
6. Ахлах зэрэг хамгаалснаас хойш мэргэжлээрээ тасралтгүй 5 жил ажилласан, сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайланг бичгээр өгөх.

7. Төгсөлтийн дараах сургалтын шүүх анагаахын сургагч багшаар ажиллаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэж, дагалдан болон шавилан сургасан байх.
8. Магистрын зэрэг хамгаалсан бол давуу тал болно.

“ЗӨВЛӨХ” зэрэг горилогч шүүх эмнэлгийн шинжээч эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

Үүнд:

1. Мэргэжлээрээ тасралтгүй 25-аас дээш жил ажилласан байх.
2. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд жил бүр хамрагдсан байна. Шүүх анагаахын үндсэн мэргэшлийн сургагч багшаар ажиллаж, магистр, клиникийн профессор цолтой байх.
3. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлыг удирдах болон төслийн багт хамтран ажилласан, сүүлийн 5 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх (дотоодод 2 өгүүлэл, гадаадад 1 өгүүлэл, нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх орж болно).
4. Шүүх анагаах ухааны оношлогооны шинэ арга, технологиос практикт нэвтрүүлэх, мэргэжлийн чиглэлээр оношлогооны бичиг баримт боловсруулах чадвартай (хууль, дүрэм, заавар, удирдамж, стандарт зэргийг боловсруулах багийг удирдсан, эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан байх.
5. Мэргэжлээрээ тасралтгүй ажилласан сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайлан бичгээр өгөх.
6. Докторын зэрэг хамгаалсан бол давуу тал болно.